

## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2025 оны 10 дугаар сарын 13-ны өдөр

№ 25/43

Улаанбаатар хот

### **Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 76.2 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “**Компани**”) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “**ТУЗ**”) -ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн АХ-25/03 тоот дүгнэлт, 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ нь 2025 оны 03 сарын 25-ны өдрийн 25/14 тоот “Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх, гэрээ байгуулах эрх олгох тухай” болон мөн өдрийн 25/15 тоот “Гэрээ байгуулах эрх олгох тухай” тогтоолуудыг тус тус баталж, “Lendable Asset Management LLC”-ийн төлөөлөлтэй олон улсын хөрөнгө оруулагчид (цаашид хамтад нь “**Санхүүжүүлэгч тал**”) -аас нийт 20 сая ам.доллар хүртэлх хэмжээний зээлийн санхүүжилт (цаашид “**Санхүүжилт**” гэх)-ийг татахтай холбоотой асуудлыг шийдвэрлэсэн болохыг тэмдэглэсүгэй.
2. Ийнхүү дээр дурдсан Санхүүжилтийн хүрээнд Компани нь Санхүүжүүлэгч тал болон “АНД ФСЖ Пти.Лтд” (цаашид “**Толгой компани**”) -тай дараах гэрээнүүд (цаашид хамтад нь “**Гэрээнүүд**” гэх)-ийг байгуулсан болохыг дурдсугай. Үүнд:
  - 2.1. Олон талт зээлийн гэрээ (Facilities Agreement);
  - 2.2. Толгой компанийн зээлийн гэрээ (Parent Company Loan/Facility Agreement);
  - 2.3. Хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ (Movables Pledge Agreement);
  - 2.4. Эрх шилжүүлэх гэрээ (Assignment Agreement);
  - 2.5. Дата дамжуулах гэрээ (Data Sharing Agreement);
  - 2.6. Хеджинг гэрээ (Hedging Agreement);
  - 2.7. Гэрээнүүдийг байгуулахтай холбоотой үйлдэгдсэн аливаа баримт бичгүүд.
3. Компани нь Гэрээнүүдийн дагуу буюу Санхүүжилтийн хүрээнд эхний ээлжинд 10 сая ам.доллар (цаашид “**Эхний санхүүжилт**” гэх)-ыг татан төвлөрүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх зорилгоо амжилттай хэрэгжүүлж байгааг дурдсугай.
4. Ийнхүү Компани нь Эхний санхүүжилтийн хүрээнд тавьсан зорилгоо амжилттай биелүүлж байгааг харгалзан Гэрээний багцад заасны дагуу Санхүүжүүлэгч талаас үлдсэн 10 сая ам.долларын санхүүжилт (цаашид “**Хоёр дахь санхүүжилт**” гэх)-ийг татан төвлөрүүлэхийг Компанид зөвшөөрсүгэй.
5. Хоёр дахь санхүүжилтийг татан төвлөрүүлэхтэй холбоотойгоор 2025 оны 04 сарын 07-ны өдөр байгуулсан Олон талт зээлийн гэрээ (Facilities Agreement)-нд дор дурдсан болон үүгээр хязгаарлагдахгүйгээр бусад нэмэлт өөрчлөлтүүд (цаашид “**Нэмэлт өөрчлөлт**” гэх)-ийг оруулахыг Компанид зөвшөөрсүгэй. Үүнд:
  - 5.1. Олон талт зээлийн гэрээ (Facilities Agreement)-ний зорилго буюу 3.1-т заасны дагуу Толгой компани нь Санхүүжүүлэгч талаас олгосон санхүүжилтийг

гагцхүү Компанийн харилцагчдын бичил зээл (Micro Loan)-ийг санхүүжүүлэхэд зарцуулах үүрэг хүлээсэн байсныг өргөтгөж, бичил зээлээс гадна Эргэлтийн хөрөнгийн зээл (Revolving Loan)-д зарцуулахаар болгож өөрчлөхийг зөвшөөрсүгэй. Үүнтэй холбоотойгоор Олон талт зээлийн гэрээний зохих хэсгүүдэд өөрчлөлт оруулах агуулга бүхий 2025 оны 04 сарын 07-ны өдрийн Олон талт санхүүжилтийн гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ (Amendment Deed relating to an up to 20,000,000 Facilities Agreement dated 7 April 2025)-г энэхүү тогтоолын Хавсралт 1А-д заасан хувилбараар баталсугай.

6. Ийнхүү Нэмэлт өөрчлөлтийг байгуулж буй нь гагцхүү Компанийн ашиг сонирхлын төлөө үйлдэл бөгөөд Компанийн бизнесийн үйл ажиллагааг өргөтгөх зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байгааг тэмдэглэсүгэй.
7. Нэмэлт өөрчлөлт, эдгээртэй дагалдах бусад гэрээ, хэлцэл, баримт бичгийг тэдгээрт дурдагдсан талуудтай эцэслэн тохиролцож байгуулах, гарын үсэг зурж баталгаажуулах, үүнтэй холбогдох шаардлагатай бусад арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
8. Хоёр дахь санхүүжилтийг татан төвлөрүүлэхтэй холбогдуулан Гэрээнүүд болон Нэмэлт өөрчлөлтөд дурдсанаар үйлдвэл зохих зөвшөөрөл, хүсэлт, мэдэгдэл болон үүгээр хязгаарлагдахгүйгээр Компанийн нэрийн өмнөөс үйлдвэл зохих аливаа баримт бичгийг үйлдэх, тэдгээрт гарын үсэг зурж баталгаажуулан холбогдох талд хүргүүлэх, хариу хүлээн авах зэрэг бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.  
лэ
9. Гэрээнүүд болон Нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан үйлдсэн аливаа баримт бичгийн хэрэгжилт, Санхүүжилт татан төвлөрүүлэлт болон ашиглалт, холбогдох бусад мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
10. Энэхүү тогтоолыг Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан шаардлагын дагуу Толгой компаниатай сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн шийдвэрээр баталсан болохыг дурдсугай.

ТУЗ-ийн гишүүд:

	/Ж.ЖАРГАЛСҮРЭН/		/С.БОРГИЛ/
	/С.НЭРГҮЙ/		/Ц.ОДМАА/
	/С.ЭНХ-АМГАЛАН/		

  
ЛЭНДМН ББСБ ЖХ  
УЛААНБААТАР ХОТ  
5039754 1118267206

**“LENDMN NBFJ” JSC**  
**RESOLUTION OF THE BOARD OF DIRECTORS**

13<sup>th</sup> day of October 2025

№ 25/43

Ulaanbaatar city

**On raising funds through loan financing and  
granting authorization for agreement execution**

**WHEREAS,**

Pursuant to Article 76.1.17, Article 76.2, Article 80, Article 89.1, and Article 92.1 of the Company Law of Mongolia, as well as Articles 9.6.4, 9.6.20, 9.6.23, 14.5.4, 20.1, 20.4, and 20.5 of the Charter of LendMN NBFJ JSC ( the "**Company**"), the Conclusion of the report by the Audit Committee of the Board of Directors of the Company ( the "**BOD**") dated 25<sup>th</sup> day of March 2025 and the Resolution of the BODs' electronic voting conducted on the 13<sup>th</sup> day of October 2025,

**NOW, THEREFORE, IT IS NOTED THAT:**

1. **The Company hereby acknowledges and records that** by its Resolution No. 25/14 dated 25 March 2025 entitled "*On Raising Funds through Loan Financing and Granting Authorization for Agreement Execution*" and Resolution No. 25/15 dated the same date entitled "*Authorization for Agreement Execution*", the BOD duly approved the raising of loan financing of up to USD 20,000,000 (the "**Financing**") from international investors represented by *Lendable Asset Management LLC* (together with its affiliates, the "**Lenders**").
2. **The Company further acknowledges that**, in connection with the Financing, it has entered into the following agreements (collectively, the "**Agreements**") with the Lenders and with *AND FSG Pte. Ltd.* (the "**Parent Company**"):
  - 2.1. Facilities Agreement;
  - 2.2. Parent Company Loan/Facility Agreement;
  - 2.3. Movables Pledge Agreement;
  - 2.4. Assignment Agreement;
  - 2.5. Data Sharing Agreement;
  - 2.6. Hedging Agreement; and
  - 2.7. Any other documents executed in connection with the Agreements.
3. **The Company further records that**, pursuant to the Financing and as provided in the Agreements, it has successfully drawn down an initial facility of USD 10,000,000 (the "**Facility A**") to implement its business expansion objectives.

**NOW, THEREFORE, BE IT RESOLVED**, that the BOD hereby approves and authorizes the following:

4. In view of the successful implementation of the objectives of the Facility A, the Company is hereby authorized to draw down the remaining USD 10,000,000 (the "**Facility B**") from the Lenders in accordance with the terms of the Agreements.

5. In connection with the drawdown of the Facility B, the Company is authorized to amend the Facilities Agreement dated 7 April 2025, including, but not limited to, the following (collectively, the “*Amendment*”):
  - 5.1. To amend Clause 3.1 (Purpose) of the Facilities Agreement so that, in addition to financing the Company’s Micro Loan portfolio, the Parent Company shall also apply the proceeds of the Financing towards the Revolving Loan portfolio, by executing an “*Amendment Deed relating to an up to USD 20,000,000 Facilities Agreement dated 7 April 2025*” in the form attached hereto as *Annex 1A*.
6. It is in the best interests of the Company to enter into the transactions contemplated by the Amendment in order to implement its business expansion objectives.
7. The Company’s Chief Executive Officer (Uuganbayar.Ts) is hereby granted full authority to finalize, agree upon, sign, execute, and deliver the Amendment, together with any other agreements, arrangements, or documents ancillary thereto, with the respective parties named therein, and to take and implement any other actions as may be necessary or appropriate in connection therewith.
8. The Company’s Chief Executive Officer (Uuganbayar.Ts) is hereby granted full authority in connection with the drawdown of the Facility B, to prepare, execute, and deliver, in the name and on behalf of the Company, any consents, requests, notices, and, without limitation, any other documents required to be executed pursuant to the Agreements and the Amendment, and to deliver such documents to the relevant parties and receive and acknowledge any responses or communications relating thereto.
9. The Company’s Chief Executive Officer (Uuganbayar.Ts) shall report regularly to the BOD on the execution, utilization, and progress of the Amendment and all relevant activities in connection with the Agreements and any relevant documents.
10. This Resolution has been adopted by those members of BOD without a conflict of interest with the Parent Company, in compliance with the requirements of the Company Law of Mongolia.

**BOARD OF THE DIRECTORS:**

 _____ /JARGALSUREN.J/	 _____ /BORGIL.S/
 _____ /NERGUI.S/	 _____ /ODMAA.TS/
 _____ /ENKH-AMGALAN.S/	

